

Ёс зүйн тайлан

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”, Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ыг үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс 2011 оныг төрийн албан хаагчийн ёс зүйн хариуцлагын жил болгон зарласан.

Ёс зүйн хариуцлагын жилийн хүрээнд хийсэн ажлыг авч үзвэл.


- Улсын хэмжээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд 618 Ёс зүйн хороо байгуулагдан тэдгээр хорооны бүрэлдэхүүнд 2490 төрийн албан хаагч, 8 иргэдийн төлөөлөл орж ажиллаж байна.
- Төрийн албаны зөвлөлийн ёс зүйн хороо, ТАЗ-ийн дэргэдэх Сургалт, судалгаа зөвлөх үйлчилгээний нэгж болон Салбар зөвлөл, төрийн захиргааны байгууллагуудын ёс зүйн хороодоос 2011 онд ёс зүйн чиглэлээр нийтдээ 47 сургалт, семинар, зөвлөгөөнийг зохион байгуулж 4404 /давхардсан тоогоор/ төрийн албан хаагч хамрагдсан байна.
- “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын 2.6, 2.7-д заасны дагуу ТАЗ-ийн ёс зүйн хороо ёс зүйн зөрчлийн тухай мэдээг төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн хороодоос хагас, бүтэн жилээр нэгтгэн авч үзэхэд, 2011 онд нийт 244 ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэснээс Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэхээр дүгнэлт гаргасан 224, ёс зүй зөрчсөн гэх үндэслэлгүй гэж үзсэн 20 тохиолдол байна. Ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэлээр нь авч үзвэл:

- Гомдлоор – 51
- Мэдээллээр – 11
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээллийн мөрөөр – 2
- Ёс зүйн хорооны санаачилгаар – 24
- Байгууллагын удирдлагын шийдвэрээр – 156

Эдгээрээс удирдах албан тушаалтны ёс зүйн 13 зөрчлийг хянан шийдвэрлэснээс Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэхээр дүгнэлт гаргасан 9, ёс зүй зөрчсөн гэх үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн 4 байна. Удирдах албан тушаалтны ёс зүйн зөрчлийг хүлээн авсан үндэслэлээр нь авч үзвэл:

- Гомдлоор - 7
- Байгууллагын удирдлагын шийдвэрээр – 6 ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэжээ.

Төрийн захиргааны албан хаагчийн Ёс зүйн зөрчил анх удаагаа гаргасан 228 албан хаагч, давтан гаргасан 16 албан хаагч байна.



Төрийн захиргааны албан хаагчаас Ёс зүйн зөрчил анх удаагаа гаргасан 228 албан хаагч, давтан гаргасан 16 албан хаагч байна. Нийт гарсан ёс зүйн зөрчлийг “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”- д заасан ёс зүйн зөрчлийг төрлөөр нь авч үзвэл.

д/д	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн төрөл /ТЗАХЁЗД/	Зөрчлийн тоо
1	4.1.1. шударга ёсны зарчмын хүрээнд: хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах;	14
2	4.1.4. хариуцлага хүлээх зарчмын хүрээнд: албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх	8
3	4.1.5. олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд: төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.	5
4	5.1.1. өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;	9
5	5.1.2. Хөдөлмөрийн хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглах;	14
6	5.1.3. үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх	1
7	5.1.4. өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх	

	ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах	7
8	5.1.5. албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх	4
9	5.2.1. Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж байгаа соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлах;	15
10	5.2.3. хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;	10
11	5.2.4. албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;	4
12	5.2.5. төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг албаны бус зорилгоор ашиглахгүй байх.	3
13	5.3.1. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;	8
14	5.3.2. төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх;	2
15	5.3.3. танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;	19
16	5.3.4. албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглох;	3
17	5.3.5. бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох	4
18	5.4.1. өөрийн мэдлэг чадвар, дадал туршлагаа байнга хөгжүүлж, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдлэх;	3
19	5.4.2. ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг биечлэн хангах;	17
20	5.4.4. захирах, захирагдах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдлагаас гаргасан хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;	25
21	5.4.5. албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, этгээд байдлаар	31

	хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;	
22	5.5.1. албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх	11
23	5.5.2. төрийн албаны соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харилцах;	11
24	5.5.3. иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг зохих дүрэм, журмын дагуу цаг алдалгүй, ил тод, түргэн шуурхай хүргэх.	16
Нийт 244 ёс зүйн зөрчил		